УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ХАМТАРСАН
ЗАХИРАМЖ, ТУШААЛ

2023 оны 10 сарын 18 өдөр Дугаар 72/А/116 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.13 дахь заалт, Шүүх шинжилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАН, ТУШААХ нь:

1.“Шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам”-ыг хавсралтаар батлагдсугай.

2.Захирамж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын дээд шүүхийн тамгын газрын дарга (С.Заяадэлгэр), Улсын ерөнхий прокурорын орлогч (Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат), Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат)-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам батлах тухай” Улсын ерөнхий прокурорын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

Б.ЖАРГАЛСАЙХАН



Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 22/А/116 дугаар хамтарсан захирамж, тушаалын I хавсралт

ШИНЖИЛГЭЭНИЙ ОБЪЕКТЫГ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, УСТГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шинжилгээний объектыг шинжилгээний байгууллага, шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдэд хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, биологийн гаралтай зарим объектыг устгахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Шинжилгээний объектыг шүүх шинжилгээний байгууллагад хүргүүлэх

2.1.Шинжилгээний объект нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасан нийтлэг болон тусгай шаардлага хангасан байна.

2.2.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний объектыг шинжилгээ хийлгэх тухай шийдвэр (мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны хүсэлт)-ийн хамт өөрийн биеэр буюу холбогдох эрх бүхий этгээдээр, эсхүл албан ёсны шуудангаар хүргүүлнэ.

2.3.Шинжилгээ хийлгэх шийдвэрийг хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, зөрчлийн холбогдогч, бусад шинжлүүлэгч этгээдэд танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан байна.

2.4.Шинжилгээний объектын хаягжуулалт (шошго)-д тухайн объектын нэр, төрөл, тоо хэмжээ, онцлог, шинж тэмдэг, хэргийн дугаар зэргийг тодорхой тэмдэглэж, түүний шинж чанар, онцлогоос хамаарч объектыг гялгар уут, цаасан уут, дугтуй, хайрцаг, тусгайлан бэлтгэсэн сав, баглаа боодол, зориулалтын саванд хийж, шинж чанарыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангаж ирүүлнэ.

2.5.Овор хэмжээ ихтэй шинжилгээний объектыг шүүх шинжилгээний байгууллага болон шуудан, тээврийн байгууллагын тавьсан шаардлагын дагуу хайрцаглан битүүмжилж, түүнд энэхүү журмын 2.4-т заасан мэдээлэл болон хүлээн авагчийн хаягийг тодорхой бичсэн байна.

2.6.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай нэмэлт объект хүргүүлэх бол энэхүү журмын 2.2, 2.3-т заасныг баримтална.

Гурав.Шинжилгээний объектыг хүлээн авах

3.1.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний объектыг хүлээж авахдаа шинжилгээ хийлгэх шийдвэрт заасан мэдээлэлтэй тулган битүүмжлэл, тоо

ширхэг, шинж байдал, бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүргэж ирсэн ажилтны нэр, албан тушаал зэргийг бүртгэн гарын үсэг зуруулж, хүлээн авна.

3.2.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний байгууллагад ирүүлсэн шинжилгээний объект хүргэлтийн явцад гэмтсэн, шинж байдлаа алдсан, битүүмжлэл задарсан, шинжилгээ хийхэд шаардлага хангахгүй болсон тохиолдолд энэ талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан болон шинжээчид мэдэгдэнэ.

3.3.Энэхүү журмын 2.5-д заасан объектыг шинжилгээний байгууллагад ирүүлсэн тохиолдолд бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, хүлээн авах эсэхийг шийдвэрлүүлнэ.

3.4.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээ хийлгэх тухай шийдвэр болон шинжилгээний объектыг хуваарилагдсан шинжээчид хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

Дөрөв.Шинжилгээний объектыг хадгалах

4.1.Шинжилгээний объектыг тусгай нөхцөл бүхий өрөөнд зориулалтын шүүгээ, хөргүүрт хадгална.

Тав.Шинжилгээний объектыг шилжүүлэх, буцаан хүргүүлэх

5.1.Шинжээч нь шинжилгээний явцад тухайн объектод өөрчлөлт орсон бол энэ талаар дүгнэлтэд тусгах ба шаардлагатай бол тайлбар бичин гарын үсэг зурж, бүртгэл, мэдээллийн ажилтанд хүлээлгэн өгнө.

5.2.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний объект, шинжээчийн дүгнэлтийг хүлээн авч, холбогдох мэдээллийг бүртгэлд тусгана.

5.3.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний объект, шинжээчийн дүгнэлтийг холбогдох эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхдөө тухайн этгээдийн нэр, албан тушаал, албаны үнэмлэхийн дугаар, огноо зэрэг мэдээллийг тэмдэглэн гарын үсэг зуруулна.

5.4.Бүртгэл, мэдээллийн ажилтан нь шинжилгээний объект, шинжээчийн дүгнэлтийг орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхдээ албан бичгийн хамт дугтуйлан битүүмжилж, албан ёсны шууданд хүлээлгэн өгнө.

5.5.Шинжилгээний объектыг энэхүү журмын 5.3, 5.4-т зааснаас бусад байдлаар хүлээлгэн өгөхийг хориглоно.

5.6.Шинжилгээний объектыг хүлээн авах, шилжүүлэх, буцаан хүргүүлэх тохиолдолд энэ журмын хавсралт нэг, хоёрт тусгасан “ШО-1”, “ШО-2” маягтыг бөглөнө.

Зургаа.Биологийн гаралтай объектыг устгах

6.1.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээ хийлгэх шийдвэрт Шүүх шинжилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасны дагуу биологийн дээжийг устгах зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг “ШО-2” маягтад тусгана.

6.2.Биологийн гаралтай шинжилгээний объектыг устгахдаа эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгахтай холбоотой батлагдсан журам, зааврыг баримтална.

6.3.Шинжилгээ хийж үлдэгдэлгүй болсон биологийн дээжийн савыг энэхүү журмын 6.2-т заасан журам, зааврыг баримтлан устгана.

Долоо.Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн алба хаагчид хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

"Шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам"-ын I хавсралт

ШО-1 УХА0014

ШИНЖИЛГЭЭНИЙ ОБЪЕКТ

Байгууллага:

_____

Албан тушаалтан:

_____

Хэргийн дугаар:

_____

Шинжилгээний объектын талаарх мэдээлэл:

_____

_____

_____

_____

Тусгай тэмдэглэл:

_____

_____

ХҮЛЭЭЛЦСЭН ТЭМДЭГЛЭЛ

Хүлээлгэн өгсөн хүний нэр, гарын үсэг	Хүлээн авсан бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Шинжилгээг хүлээлгэн өгсөн бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Хүлээн авсан шинжээчийн нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Дүгнэлт, объектыг хүлээлгэн өгсөн шинжээчийн нэр, гарын үсэг	Хүлээн авсан бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Шинжээчийн дүгнэлт, шинжилгээний объектыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн нэр, гарын үсэг	Хүлээлгэн өгсөн бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

---oOo---

"Шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам"-ын II хавсралт

ШО-2

ШИНЖИЛГЭЭНИЙ ОБЪЕКТ

Байгууллага:

_____

Албан тушаалтан:

_____

Хэргийн дугаар:

_____

Шинжилгээний объектын талаарх мэдээлэл:

_____

_____

Шинжилгээний явцад авсан биологийн дээжийг устгах зөвшөөрөл:

_____

_____

_____

ХҮЛЭЭЛЦСЭН ТЭМДЭГЛЭЛ

Хүлээлгэн өгсөн хүний нэр, гарын үсэг	Хүлээн авсан бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Шинжилгээг хүлээлгэн өгсөн бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Хүлээн авсан шинжээчийн нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Дүгнэлт, объектыг хүлээлгэн өгсөн шинжээчийн нэр, гарын үсэг	Хүлээн авсан бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

Тусгай тэмдэглэл: Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн дагуу биологийн дээжийг устгасан талаарх мэдээлэл.

№	Шалтгаан нөхцөл	Устгасан талаарх мэдээлэл
1	Шинж чанараа алдсан	
2	Шинжилгээнд дахин ашиглах боломжгүй болсон	
3	Адилтгал, мэдээллийн санд хадгалсан	
4	Бусад тайлбар	

Шинжээчийн дүгнэлт, шинжилгээний объектыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн нэр, гарын үсэг	Хүлээлгэн өгсөн бүртгэл, мэдээллийн ажилтны нэр, гарын үсэг	Огноо, цаг минут

---oOo---